



ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/03

Улаанбаатар хот
2012 он



ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуй салбар	2
2. Аж үйлдвэрийн салбар	7
3. Хүнсний үйлдвэрийн салбар	9
4. Цаг агаар	12

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

1. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 3.8 сая хээлтэгч буюу 24.2 хувь нь 2012 оны эхний улирлын байдлаар төллөсөн байна. Эм хонины 27.3 хувь, эм ямааны 19.0 хувь, ингэний 1.8 хувь, гүүний 1.6 хувь, үнээний 1.0 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.0 хувь буюу 3774.2 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 938.9 мянга буюу 33.1 хувиар их байна.

Унага бойжилт 98.6 хувь, тугал 97.5 хувь, ботго 99.4 хувь, хурга 99.2 хувь, ишиг 98.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.6-2.4 пунктээр өссөн.

Том малын зүй бус хорогдол 2012 оны эхний улиралд улсын хэмжээнд 123.0 мян. толгойд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 134.9 мян.толгой буюу 52.3 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 5.9 мянга, үхэр 11.8 мянга, тэмээ 0.2 мянга, хонь 45.5 мянга, ямаа 59.6 мянга байна. Нийт хорогдлын 37.0 хувийг хонь, 48.5 хувийг ямаа эзэлж байна.

Мал төллөлт (жил бүрийн эхний улирлын байдлаар)

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³
Бүгд	2747.7	2919.4	3801.9	14.5	18.8	24.2
Гүү	7.4	5.6	15.1	1.1	1.0	1.6
Үнээ	40.6	32.1	69.3	4.0	3.6	1.0
Ингэ	6.8	8.1	11.6	7.6	8.9	1.8
Эм хонь	1551.6	1463.9	1877.7	17.9	20.6	27.3
Эм ямаа	1141.3	1409.6	1828.2	13.3	20.6	19.0

Төл бойжилт (жил бүрийн эхний улирлын байдлаар)

Төлийн төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³
Бүгд	2130.8	2835.3	3774.2	77.4	96.9	99.0
Унага	6.4	5.5	14.9	86.8	96.8	98.6
Тугал	35.8	31.3	67.5	88.2	97.5	97.5
Ботго	6.7	8.0	11.5	97.5	98.7	99.4
Хурга	1223.8	1419.3	1867.1	78.7	96.8	99.2
Ишиг	858.1	1371.3	1813.1	74.9	97.0	98.9

**Зүй бусаар хорогдсон том мал
(жил бүрийн эхний улирлын байдлаар)**

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³	2010 ¹⁻³	2011 ¹⁻³	2012 ¹⁻³
Бүгд	6310,8	257,9	123,0	14,3	0,8	0,3
Тэмээ	3,8	0,4	0,2	1,4	0,1	0,1
Адуу	207,5	9,0	5,9	9,3	0,5	0,3
Үхэр	347,3	21,8	11,8	13,4	1,0	0,5
Хонь	2501,5	107,6	45,5	13,0	0,7	0,3
Ямаа	3250,7	119,2	59,6	16,5	0,9	0,4

ХӨДӨӨ АЖ АХҮЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Аймаг, нийслэл	I ширхэгийн дундаж үнэ, төг.				
	Хонины/ноостой нэхий, ширхэг/		Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг		
	2011.III	2012.III	2011.III	2012.III	
Баруун бүс					
Баян-Өлгий		6500	-	21000	19000
Говь-Алтай		7000	16000	18000	25000
Завхан		6500	17000	18500	22000
Увс		4000	10500	16000	17000
Ховд		-	18000	-	25000
Хангайн бүс					
Архангай		4500	8000	18000	23000
Баянхонгор		5500	13000	18000	25000
Булган		6800	7500	12000	19000
Орхон		4000	5500	14000	12000
Өвөрхангай		7500	8000	20000	-
Хөвсгөл		4000	8000	16000	18000
Төвийн бүс					
Говьсүмбэр		5000	10000	18000	21000
Дархан-Уул		7000	15000	18000	23000
Дорноговь		7000	10000	15000	16000
Дундговь		6200	13700	21500	25300
Өмнөговь		6000	10000	18000	20000
Сэлэнгэ		6000	18000	18000	20000
Төв		6000	15000	17500	25000
Зүүн бүс					
Дорнод		4300	12000	15000	20700
Сүхбаатар		4000	-	15000	-
Хэнтий		5000	10000	-	20000
Улаанбаатар					
Улаанбаатар		7000	10000	20000	22000

Аймаг, нийслэл	I ширхэгийн дундаж үнэ, төг.				
	Үхрийн шир				
	2 м-ээс доош урттай		2 м-ээс дээш урттай		
	2011.III	2012.III	2011.III	2012.III	
Баруун бүс					
Баян-Өлгий	10500	21500	15500	25000	
Говь-Алтай	13000	18700	-	28700	
Завхан	10000	25000	15000	30000	
Увс	11000	22000	15000	25000	
Ховд	-	-	15000	28000	
Хангайн бүс					
Архангай	15000	30000	25000	38000	
Баянхонгор	13000	28000	-	30000	
Булган	12000	30000	22000	35000	
Орхон	14000	26000	20500	37000	
Өвөрхангай	-	25000	18000	30000	
Хөвсгөл	15000	30000	22000	35000	
Төвийн бүс					
Говьсүмбэр	-	20000	-	25000	
Дархан-Уул	15000	26000	23000	34000	
Дорноговь	-	-	-	-	
Дундговь	-	-	-	26700	
Өмнөговь	10000	-	-	-	
Сэлэнгэ	14000	28000	25000	38000	
Төв	15500	30000	23500	40000	
Зүүн бүс					
Дорнод	10000	27000	20000	35000	
Сүхбаатар	12500	22500	20000	30000	
Хэнтий	12000	30000	-	-	
Улаанбаатар					
Улаанбаатар	17000	33000	25000	40000	

Аймаг, нийслэл	I ширхэгийн дундаж үнэ, төг.						
	Адууны шир, ширхэг			Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг		
	2011.III	2012.III			2011.III	2012.III	
Баруун бүс				Төвийн бүс			
Баян-Өлгий	22000	30000		Говьсүмбэр	-	32500	
Говь-Алтай	20500	33000		Дархан-Уул	24000	30000	
Завхан	20000	30000		Дорноговь	-	28000	
Увс	20000	24000		Дундговь	20500	35700	
Ховд	18000	40000		Өмнөговь	18000	30000	
Хангайн бүс				Сэлэнгэ			
					22000	38000	

Архангай	25000	35000	Төв	22500	40000
Баянхонгор	18000	35000	Зүүн бүс		
Булган	20000	35000	Дорнод	20000	35300
Орхон	24000	35000	Сүхбаатар	20000	32500
Өвөрхангай	25000	35000	Хэнтий	20000	35000
Хөвсгөл	23000	30000	Улаанбаатар		
			Улаанбаатар	26000	37000

Аймаг, нийслэл	1кг-ын дундаж үнэ, төг.				
	Ямааны ноолуур, кг				
	Цагаан		Бор		
	2011.III	2012.III	2011.III	2012.III	
Баруун бүс					
Баян-Өлгий	-	50000	49000	50000	
Говь-Алтай	46500	49700	46500	49700	
Завхан	-	53000	-	53000	
Увс	45000	48000	-	-	
Ховд	47000	52000	-	52000	
Хангайн бүс					
Архангай	65000	60000	65000	60000	
Баянхонгор	55000	53000	55000	50000	
Булган	-	60000	65000	60000	
Орхон	58000	66500	60000	65000	
Өвөрхангай	60000	62000	60000	62000	
Хөвсгөл	65000	64000	69000	65000	
Төвийн бүс					
Говьсүмбэр	71000	68500	-	-	
Дархан-Уул	70000	62000	70000	62000	
Дорноговь	70000	65000	70000	65000	
Дундговь	67000	63000	-	-	
Өмнөговь	50000	55000	-	50000	
Сэлэнгэ	65000	-	65000	-	
Төв	64500	65000	64500	65000	
Зүүн бүс					
Дорнод	64500	72800	64500	72800	
Сүхбаатар	71500	66500	71500	66500	
Хэнтий	65000	69000	55000	-	
Улаанбаатар					
Улаанбаатар	68000	65000	68000	65000	

2.АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний улиралд 1140.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 151.3 тэрбум төг буюу 15.3 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний улиралд оны үнээр 1249.6 тэрбум төг болж, үүний 794.0 тэрбум төг буюу 63.5 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^{III}	2012 ^{III}	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	$\frac{2012^{I-III}}{2011^{I-III}}$ (%)
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр	155723.1	172839.8	422852.4	460596.2	108.9
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	35421.0	42817.2	104566.2	117624.3	112.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	22456.8	26328.5	66044.2	75812.5	114.8
Тамхи үйлдвэрлэл	416.7	370.3	2921.0	2231.8	76.4
Нэхмэлийн үйлдвэрлэл	3687.8	4514.1	13195.2	12831.3	97.2
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	580.6	399.1	1905.9	1299.8	68.2
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	25.3	97.5	80.7	295.7	366.3
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	166.7	185.2	505.5	493.9	97.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	177.0	283.2	456.9	767.5	168.0

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^{III}	2012 ^{III}	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	Үүнээс: гадаадад
Аж үйлдвэр, бүгд	399800.2	531643.1	1028745.8	1249644.5	793976.8
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	65487.7	131212.3	195776.8	335552.5	97085.5

Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	40943.3	51296.3	127794.0	169127.8	1826.6
Тамхи үйлдвэрлэл	2700.0	2503.8	8400.0	9325.3	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	4738.7	5707.0	20753.9	19706.4	5506.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	565.0	540.7	2333.2	2201.4	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	56.2	110.5	153.4	278.8	-
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	704.1	811.9	1878.3	2068.0	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	580.9	1080.3	2361.5	2678.8	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	120.5	99.8	213.6	274.9	1.9




Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{III}	2012 ^{III}	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	$\frac{2012^{I-III}}{2011^{I-III}} \%$
Хивс	мян.м2	58.7	77.5	194.0	236.2	121.8
Сүлжмэл эдлэл	мян.ш	45.6	47.6	149.6	133.5	89.2
Самнасан ноолуур	тн	4.2	6.5	33.6	18.9	56.3
Эсгий	мян.м	6,3	20.0	19.7	84.9	431.0
Тэмээний ноосон хөнжил	мян.м	2.1	0.1	8.4	2.2	26.2
Эсгий гутал	мян.хос	2.8	2.8	9.5	7.3	76.8
Нэхий дээл	ш	965	169	4670	2004	42.9
Савхин гутал, ботинк	мян.хос	0.4	1.7	1.3	3.5	262.7
Барилгын модон хаалга, цонх	м2	408.8	285.5	1561.1	919.2	58.9
Барилгын шалны банз	м3	108.0	115.4	108.0	341.5	316.2
Зүсмэл материал	м3	697.6	885.2	1312.7	1524.8	116.2
Дэвтэр	мян.ш	402.0	2.6	1378.8	1991.5	144.4
Ариун цэврийн цаас	мян.ш	90.2	469.2	318.6	698.7	219.3
Бичгийн цаас	тн	24,9	34.2	72.8	38.4	52.7
Сонин	сая.х.д.х	3.3	3.8	9.0	11.7	129.6
Ном	сая.х.д.х	3.7	4.2	9.9	12.3	124.7

3.ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{III}	2012 ^{III}	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	$\frac{2012^{I-III}}{2011^{I-III}} \%$
Үхрийн мах	тн	11.3	4.7	183.5	444.7	242.3
Хонины мах	тн	6.1	-	233.9	409.9	175.2
Адууны мах	тн	0.7	-	55.1	16.8	30.5
Ямааны мах	тн	7.6	-	59.7	299.5	501.7
Гахайн мах	тн	4.4	1.7	6.1	4.4	72.1
Өлөн гэдэс	мян.гогцоо	87.9	133.5	232.2	336.0	144.7
Хиамны зүйл	тн	172.2	144.7	484.4	442.4	91.3
Боловсруулсан						
шингэн сүү	мян.л	1887.5	1669.3	5601.4	6498.9	116.0
Тараг	мян.л	782.4	635.9	1738.1	1339.0	77.0
Цөцгий, цөцгийн тос	тн	69.6	139.1	252.4	406.0	160.9
Аарц, бяслаг	тн	0.2	6.7	22.2	35.2	158.6
Дээд гурил	тн	914.0	1512.4	6375.3	3889.8	61.0
Нэгдүгээр гурил	тн	7078.8	4506.1	19810.1	14066.2	71.0
Хоёрдугаар гурил	тн	1168.0	1179.3	2434.9	2257.2	92.7
Малын тэжээл	тн	3698.7	2277.5	10176.5	6871.1	67.5
Талх	тн	1830.7	1886.1	4858.1	5962.6	122.7
Нарийн боов	тн	847.3	612.7	2852.2	3256.5	114.2
Бялуу	тн	25.6	89.5	89.4	154.9	173.3
Чихэр	тн	6.6	4.3	27.4	24.6	89.8
Гоймон	тн	291.1	5.0	461.3	268.8	58.3
Спирт	мян.л	281.4	435.5	1130.3	1173.1	103.8
Архи	мян.л	1959.7	2461.4	6740.4	7248.1	107.5
Дарс	мян.л	7.7	6.1	28.9	21.8	75.4
Шар айраг	мян.л	4742.7	5449.3	12403.9	15405.5	124.2
Цэвэр ус	мян.л	2072.3	2441.3	4692.7	6118.8	130.4
Амтат ус, ундаа	мян.л	4569.7	6571.9	9525.9	13474.2	141.4
Жүүс	мян.л	3081.0	6053.5	7635.4	14109.1	184.8



Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	$\frac{2012^{I-III}}{2011^{I-III}} \%$
Үхрийн хөлдүү мах	т	1351.5	-	
Адууны мах	т	73.8	250.1	339.1
Малын дайвар бүтээгдэхүүн	т	242.5	868.9	358.4
Шеврет	сая дм ²	69.2	68.9	99.5
Шевро	сая дм ²	46.5	26.5	56.9
Адууны шир	мян.ш	98.3	56.5	57.5
Хонины самнаагүй ноос	т	3148.6	736.0	23.4
Бохир ноолуур	т	38.0	24.3	63.9
Самнасан ноолуур	т	15,6	89.6	576.4
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	8.6	3.2	36.6

Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	$\frac{2012^{I-III}}{2011^{I-III}} \%$
Өндөг	мян.ш	15899.5	16723.4	105.2
Төмс	т	554.2	191.4	34.5
Сонгино, сармис	т	2553.6	3526.8	138.1
Алим, лийр	т	1525.9	719.8	47.2
Ногоон цай	т	571.5	549.3	96.1
Цагаан будаа	т	2153.0	2148.1	99.8
Шар будаа	т	408.9	372.7	91.1
Улаанбуудай	мян.т	-	1.0	
Гурил	мян.т	9.9	20.2	203.7
Ургамлын тос	т	713.5	1644.7	230.5
Элсэн чихэр	т	9588.5	9280.9	96.8
Хатуу чихэр	т	2520.5	1285.5	51.0
Согтууруулах биш ундаа	мян.л	1315.7	1798.1	136.7
Согтууруулах ундаа	мян.л	2178.0	4040.1	185.5
Үүнээс: Шар айраг	мян.л	2078,3	3931.4	189.2
Янжуур	сая.ш	441.0	481.1	109.1

4.ЦАГ АГААР

2012 ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ **


УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Тавдугаар сарын агаарын температурын дундаж нь Алтайн өвөр говь болон Заг сүүж, Өөшийн говиор 16-20, Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутгаар 5-9, бусад нутгаар 10-15 градус дулаан байдаг. Гэвч энэ нь жил бүр харилцан адилгүй байдаг. Тухайлбал: Сүүлийн жилүүдийн байдлаар 1989, 1992, 1999, 2000, 2002, 2007, 2009 онд олон жилийн дунджаас 2-3 градусаар дулаан байж, өдрийн үнэмлэхүй их температур 30-35 градус хүрч халж байсан бол 1995 онд бүх нутгаар 2-3 градусаар хүйтэн байжээ.


Олон жилийн дундаж байдлаар Хангайн нурууны ар тал, Эрээний нуруу дагуу болон Орхон-Сэлэнгийн сав нутгаар 21-30, Их нууруудын хотгор, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр болон Заг сүүж, Өөшийн говиор 3-12, бусад нутгаар 13-20 мм хур тунадас ордог. Гэвч сүүлийн жилүүдийн байдлаар 1996, 1998 онд тун бага хур тунадас орж, их хуурай халуун байснаас ой хээрийн түймэр ихтэй байлаа. Харин 1988, 1990, 1999, 2002, 2003 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1-3 дахин их хур тунадас оржээ.

Тавдугаар сард салхины хурд 15 м/с-ээс дээш ширүүсч шороон шуурга шуурах тохиолдол олон жилийн дунджаар говь болон зүүн зүгийн нутгаар 10-15, бусад нутгаар 5-7 удаа ажиглагддаг. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины хамгийн их хурд 1991 онд Увс, Говь-Алтайн нутгаар 28-34 м/с, 1993, 1996 онд Говь-Алтай, Өвөрхангай, Хэнтэй, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговийн нутгаар 34-40 м/с хүртэл ширүүсч хүчтэй шороон болон цасан шуурга шуурч иргэд, аж ахуйн байгууллагуудад ихээхэн хэмжээний хохирол учруулж байжээ.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ



4 дугаар зураг. 5 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан мэдээ
Precipitation forecast, May



3 дугаар зураг. 5 дугаар сарын агаарын температурын урьдчилсан мэдээ
Air temperature forecast, May

Баруун зүгийн нутаг. The western region. Агаарын температурын сарын дундаж нь Алтай, Хангайн уулархаг нутгаар 5-9, Алтайн өвөр говиор 15-19, бусад хэсгээр 10-15 градус дулаан байх бөгөөд Увсын зүүн хойд, Завханы хойд хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар дундагийн орчим байна (**3 дугаар зураг**).

Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үеэр сэрүүсч Увс, Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Увс, Завханы баруун өмнөд хэсгээр шөнөдөө 0-5, өдөртөө 11-16 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр бага зэрэг сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, өдөртөө 11-16 градус дулаан байна. Харин



нэгдүгээр арав хоногийн сүүлийн хагас, гуравдугаар арав хоногийн эхээр Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 8-13, өдөртөө 23-28 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4-9, өдөртөө 18-23 градус дулаан байна. Бусад хугацаанд Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 5-10, өдөртөө 20-25 градус дулаан, уулархаг нутгаар шөнөдөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, өдөртөө 12-17 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6, өдөртөө 15-20 градус дулаан байна.

Энэ сард Баян-Өлгийн өмнөд, Завханы хойд, Говь-Алтайн зүүн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Ховдын ихэнх нутаг, Увсын өмнөд, Говь-Алтайн баруун, Завханы баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орно ([4 дүгээр зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн зүүн хэсгээр хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно. Харин гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим нутгаар бороо орох төлөвтэй. Дээрх үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с, зарим үед 24 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Төвийн нутаг. The central region. Агаарын температурын сарын дундаж нь Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Өвөрхангайн баруун хойд, Төв аймгийн зүүн хэсгээр 4-9, бусад хэсгээр 10-15 градус дулаан буюу Хөвсгөлийн хойд хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эх болон дунд үеэр сэрүүсч Дархадын хотгороор шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна. Хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг сэрүүсч ихэнх нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар шөнөдөө 6-11, өдөртөө 19-24 градус дулаан, Орхон-Сэлэнгийн хөндийгөөр 23-28 градус хүрч дулаарах төлөвтэй. Бусад хугацаанд Дархадын хотгороор шөнөдөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан, өдөртөө 10-15 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 14-19 градус дулаан, Орхон, Сэлэнгийн хөндийгөөр 18-23 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хөвсгөлийн зүүн, Архангай, Булганы хойд, Сэлэнгийн баруун, Төв, Сэлэнгийн зүүн хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Архангайн зүүн, Өвөрхангайн хойд, Булганы өмнөд, Төв аймгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үе болон эцсээр нь ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, сүүлчээр нь нутгийн зүүн хэсгээр хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно. Харин гуравдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр зарим нутгаар бороо орох төлөвтэй. Дээрх үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с, ялангуяа нэг ба хоёр, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Зүүн зүгийн нутаг. The eastern region. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 10-15 градус дулаан ба Хэнтийн хойд хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эх болон дунд үеэр нутгийн хойд хэсгээр шөнөдөө 6-11 градус хүйтэн өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус дулаан байна. Мөн хоёр, гуравдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав

хоногийн эцсээр өмнөх үеэсээ 4-6 градусаар сэрүүсч ихэнх нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан байна. Бусад хугацаанд бүх нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 16-21 градус дулаан байх ба ялангуяа хоёр ба гуравдугаар арав хоногийн эхний хагасын зарим өдөр 21-26 градус хүрч дулаарна.

Энэ сард Хэнтийн ихэнх нутаг, Сүхбаатарын зүүн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Дорнодын зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үеэр нь ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар хур тунадас, Хэнтийн уулсаар нойтон цас орно. Харин хоёрдугаар арав хоногийн эцэс, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр ихэнх нутгаар бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Дээрх үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн эхэн ба нэг, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар 18-20 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Говийн нутаг. *The gobian region.* Агаарын температурын сарын дундаж нь Өмнөговь, Дорноговийн өмнөд хэсгээр 15-19, бусад нутгаар 9-14 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эх болон дунд үеэр ихэнх нутгаар шөнөдөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан, өдөртөө 10-15 градус дулаан байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд үеэр өмнөх үеэсээ 4-6 градусаар сэрүүсч ихэнх нутгаар шөнөдөө 1-6, өдөртөө 14-19 градус дулаан байна. Харин хоёр ба гуравдугаар арав хоногийн эхний хагасын зарим өдөр 23-28 градус хүрч дулаарна. Бусад хугацаанд бүх нутгаар шөнөдөө 4-9, өдөртөө 19-24 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Өмнөговь, Дундговийн зүүн, Говь-сүмбэр, Дорноговийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, Өмнөговийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе ба эцсээр зарим газраар хур тунадас орно. Хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим газраар бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаанд салхи 12-14 м/с, ялангуяа нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үе ба сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 16-18 м/с, зарим үед 24-28 м/с хүртэл ширүүсч их төлөв шороон шуурга шуурах төлөвтэй.

** - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн